

БАТЛАВ.

СУРГАЛТЫН МЕНЕЖЕР.....Б.ЭНХБОЛОР

Долоодой сургуулийн ангийн сурагч

IV АНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Хугацаа: 40 минут

А ХУВИЛБАР

нийт 24 оноо

Эхийг анхааралтай уншаад даалгавраа гүйцэтгээрэй.

Амжилт хүсье.

Бар үнэг хоёр

Үнэг нэг удаа маш өтгөн ой шугуйгаар явж байтал бартай тааралджээ. Айж сандран хамаг хурдаараа зугтаахад бар хойноос нь хөөв. Үнэг яг баригддагийн даваан дээр өмнө нь жалга таарав гэнэ.

Тэгтэл үнэг гэнэт зогсон, уйлж гарчээ. Бар зогсоод гайхан асуув :

- Чи яагаад уйлаад байгаа юм бэ? гэхэд үнэг хариуд нь :
- Таныг би хараад танай аавыг гэнэт саналаа. Тэр маш авхаалжтай, ямар ч өргөн жалга дээгүүр үсрээд л гарч чаддаг байсан юм. Одоо ч тийм уран чадварыг дахин үзэхгүй биз дээ гэж гэнэ.

Өөрийн авхаалж самбаагаа үнэгний өмнө гайхуулах гэсэн бар энэ хорвоогийн бүхий л зүйлийг мартаж орхиод жалган дээгүүр үсэрч гэнэ. Тэгэхдээ жалган дээгүүр харайн гарч чадалгүй жалга руу уначихжээ.

Зальтай үнэг :

- Би мэдэж байсан юм. Та эцгийнхээ ухаанд хүрэх хол байна даа гэж хэлээд цааш одож гэнэ.

Нэгдүгээр хэсэг : Сонгох даалгавар тус бүр 1 оноотой

1. Бар хаана явж байгаад үнэгтэй таарсан бэ?
А. ойд Б. ой шугуй В. шугуй Г.ууланд
2. Үнэг яагаад гэнэт уйлсан бэ?
А. Бараас айсан учраас
Б. Аавыгаа санасан учраас
В. Барыг хуурах заль гаргахын тулд худлаа уйлсан
3. Бар яагаад жалганд унасан бэ?
А. Бар уран чадвартай учраас үсрэх гэж байгаад унасан.
Б. Үнэгний арга залинд ороод, гайхуулах гэж байгаад унасан.
В. Бар авхаалж самбаатай учраас бодож байгаад үсэрсэн.
4. Тодруулсан үгийг ямар үгээр солиход утга алдагдахгүй байх вэ?
Тэгэхдээ жалган дээгүүр **харайн** гарч чадалгүй жалга руу уначихжээ.
А. Үсрэн Б. харайн В. авиран Г.зөв хариу алга
5. Үйл явдлыг зөв дараалалд оруулна уу?
1. Эцгийнхээ ухаанд хүрэх хол байна даа
2. Үнэг гэнэт зогсон уйлж гарчээ.
3. Жалган дээгүүр үсэрч гэнэ.
4. Үнэг явж байгаад бартай тааралджээ
А. 4, 2, 1, 3 Б. 2, 4, 1, 3 В. 4, 2, 3,1 Г. 4, 1, 3, 2

Монгол хэл - Түлхүүр

Үнэлэх журам : Хувилбар А

Хэсэг	Даалгавар	Хариулт	оноо	Тайлбар
Нэгдүгээр хэсэг : Сонгох даалгавар	1	Б	1	
	2	В	1	
	3	Б	1	
	4	А	1	
	5	В	1	
	6	Б	1	
	7	А	1	
	8	Б	1	
	9	В	1	
	10	Б	1	
Хоёрдугаар хэсэг : Задгай даалгавар	1	Утга ялган өгүүлбэр зөв зохиосон бол тус бүр 1 оноо	2	
	2	Зөв холбосон үг бүр 1 оноо	2	
	3	Залгавар зөв залгасан үг тус бүр 1 оноо	3	
	4	Гайхуулах, мартаж	2	
	захидал	Найруулга	2	
	бичсэн эсэх	Зөв бичих дүрмийн алдаа	2	
	Бичгийн соёл	1		
Нийт оноо			24	

IV АНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Хугацаа: 40 минут

А ХУВИЛБАР

нийт 24 оноо

Эхийг анхааралтай уншаад даалгавраа гүйцэтгээрэй.

Амжилт хүсье.

Баавгайг шийтгэсэн нь

Нэгэн цагт хөвчийн эзэн баавгай ойн амьтдын амар тайван амьдралд тун ч их саад болдог байжээ. Тэр, аймшигтай чанга хурхирч, мод бутыг хуга гишгэж, шувууны үүрийг сүйтгэдэг байлаа.

Амьтад, тайгын эзний болхи бүдүүлэг байдлыг өөрт нь ойлгуулахыг хэчнээн оролдсон ч тэдний үгийг сонсохыг ч хүсдэггүй байлаа. Аргаа барсан амьтад түүнийг ойн шүүхэд өгчээ. Амьтад, шүүгчид баавгайн талаар зэрэг зэрэг гомдол мэдүүлж гэнэ. Олны өмнө ийм эвгүй байдалд орж үзээгүй тэр гэмээ ухаарч, ичсэндээ нүүрээ хийх газаргүй болов.

Ойн шүүхээс баавгайд бүхэл өвөлжингөө үүрнээсээ гаралгүй унтаж байх шийтгэл оногдуулж гэнэ. Тэр цагаас хойш майга хөлт баавгай өөрийн бүдүүлэг зангийн уршгаар хүртсэн шийтгэлээ эдэлж, өвөл ичдэг болсон гэнэ.

Нэгдүгээр хэсэг : Сонгох даалгавар тус бүр 1 оноотой

1. Эх хэдэн догол мөрөөс бүтсэн байна вэ?
А. 2 Б. 3 В. 4
3. Эхийн гол санааг олоорой .
А. Баавгайг шүүхэд өгөх тухай
Б. Баавгайд шийтгэл оногдуулах тухай
В. Баавгайг хүмүүжүүлэх тухай
Г. Аль нь ч биш
- 4 . Баавгайд ямар шийтгэл оногдуулсан бэ?
А. Өвөлжингөө унтах
Б. Өвөлжингөө үүрнээсээ гарахгүй унтах
В. Бүдүүлэг зан авир гаргахгүй байх
Г. Баавгайг шүүхэд өгсөн
5. Амьтад, шүүгчид баавгайн талаар зэрэг зэрэг мэдүүлж гэнэ.
А. өргөдөл Б. захидал В. гомдол Г. урилга
6. “Нүүр хийх газаргүй болох” хэлц үгийн утгыг зөв тайлбарласан хэсгийг сонгоно уу?
А. ичиж зовох Б. нүүрээ нуух В. нуугдах Г. зөв хариу алга
7. Баавгай өөрийн гэмээ ухаарсан болов уу?
А. тийм Б. үгүй
9. Баавгай ямар буруу үйлдэл хийсэн бэ?
Тэр чанга, мод бутыг хуга байлаа.
А. хурхирч, дэвсэж Б. хурхирч, гишгэж В. бурхирч, гишгэж
10.яагаад өвөл ичдэг болсон бэ?
А. амьтад Б. тарвага В. баавгай Г. шүүгч
11. Баавгайгаар хүний ямар зан чанарыг илэрхийлж байна вэ?
А. онгироо Б. шийтгүүлсэн В. дээрэлхүү Г. сагсуу

Монгол хэл - Түлхүүр

Үнэлэх журам : Хувилбар Б

Хэсэг	Даалгавар	Хариулт	оноо	Тайлбар
Нэгдүгээр хэсэг : Сонгох даалгавар	1	Б	1	
	2	В	1	
	3	Б	1	
	4	В	1	
	5	А	1	
	6	А	1	
	7	Б	1	
	8	В	1	
	9	В	1	
	10	А	1	
Хоёрдугаар хэсэг : Задгай даалгавар	1	Утга ялган өгүүлбэр зөв зохиосон бол тус бүр 1 оноо	2	
	2	Зөв үг бүр 1 оноо	2	
	3	Залгавар зөв залгасан үг тус бүр 1 оноо	3	
	4	Майга, бүдүүлэг	3	
	захидал	Найруулга	2	
	бичсэн	Зөв бичих дүрмийн алдаа	2	
	эсэх	Бичгийн соёл	1	
Нийт оноо			24	